

“САВ, БАГЛАА БООДОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ БОЛОВ.

Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаадын буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалтыг татах зорилготой зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 08.30-12.30 цагт ГХЯ-ны хурлын “Зөвшилцөл” танхимд зохион байгууллаа.

Тус уулзалтад өндөр ач холбогдол өгч ОХУ, Франц, Чех, Турк, Кувейт, Беларусь, Арабын Нэгдсэн Эмират, Болгар, Вьетнам улсын Элчин сайдын яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Дэлхийн банк, Мерси кор, Глобал коммунитис, Каритас Монгол зэрэг олон улсын байгууллага, манай улсад хэрэгжиж байгаа олон улсын хөтөлбөр, төслийн нэгжүүд, үндэсний хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх яам, агентлагууд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэм, шинжилгээ, судалгааны байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 100 гаруй хүн оролцлоо.

“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн зөвлөлдөх уулзалтыг нээж ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Энх-Амар, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтын газрын дарга Б.Доржсэмбэд нар үг хэллээ.

Тус зөвлөлдөх уулзалтад ХХААХҮЯ-наас “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн талаар, ЭМЯ-наас “Хүнсний зориулалтын бус савны хэрэглээ – хүний эрүүл мэнд” сэдвээр, БОАЖЯ-наас “Хуванцар сав – хог хаягдал – хүрээлэн буй орчин” сэдвээр, СХЗГ-наас “Хүнсний сав, баглаа боодол - стандартчилал” сэдвээр, МХЕГ-аас “Хүнсний сав, баглаа боодол – хяналт шалгалт” сэдвээр, ШӨХТГ-аас “Хүнсний сав, баглаа боодол – хэрэглэгчийн боловсрол” сэдвээр, “Заша өвс” НҮТББ болон Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбооноос “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ-ын оролцоо” сэдвээр тус бүр танилцуулга, мэдээлэл хийлээ.

Мөн уулзалтын үеэр гадаадын донор, олон улсын байгууллагуудад “Сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх”, “Худгийн ундны усны сав”, “Сүү, цагаан идээний сав”, “Уламжлалт сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих”, “Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах” гэсэн 5 төслийг товч танилцууллаа.

Эдгээр төслийг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлснээр хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг бууруулах, зориулалтын бус савыг зориулалтын саваар солих, дотоодын сав, баглаа боодлын үйлдвэрлэлийн салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, уламжлалт сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, хүнсний зориулалтын сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлыг хянах лабораториудын чадавхийг сайжруулах нөхцөл, боломж бүрдэнэ гэж үзэж байна.

“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг гадаад улсын болон олон улсын байгууллагуудад танилцуулах, хөтөлбөрт тусгагдсан зорилтот арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх санал солилцох, хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлоход тус зөвлөлдөх уулзалт чухал ач холбогдолтой байлаа.

Зөвлөлдөх уулзалтад оролцогчид “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн чухлыг онцолж, үндэсний хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн төслүүдэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэм

шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны талаар харилцан ярилцаж, санал, мэдээлэл солилцлоо.

Зөвлөлдөх уулзалтын үеэр дотоодын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэнг гаргасан нь оролцогчдын сонирхлыг ихэд татаж байлаа. Үзэсгэлэнд модон сав, айрагны хөхүүр, зэс, гуулин сав суулга, аяга, халбага, цаасан хайрцаг, ороогч, багцлагч, хүнсний зориулалтын сав, гялгар уут үйлдвэрлэгч дотоодын 10 гаруй аж ахуйн нэгж оролцож, бүтээгдэхүүнээ танилцууллаа.

“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагаас:

1. ДЭМБ-ын санхүүжилтээр “Хордлого судлал, эрдэм шинжилгээний нийгэмлэг”-ээс хүнсний зориулалтаар ашиглаж байгаа хуванцар савны хэрэглээг тандах зорилгоор гурван аймаг, Улаанбаатар хотын 297 өрхийг харуулсан хийсэн 2015 оны судалгаагаар нийт өрхийн 90 хувь нь хуванцар сав хэрэглэдэг бөгөөд хүнсний бүтээгдэхүүн хадгалах зорилгоор нэг өрх дунджаар 20-100 литрийн багтаамжтай 3-4 ширхэг зориулалтын бус хуванцар сав ашигладаг гэсэн дүн гарсан. Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг, судалгаанд хамрагдагсдын 78 хувьд дутмаг байгааг тогтоосон.

2. Хүнсний зориулалтын бус хуванцар савны найрлагад ордог химийн бодисууд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шилжиж, хүний биед орж хуримтлагдан олон төрлийн өвчний суурь шалтгаан болоод зогсохгүй хорт хавдар үүсгэдэг гол хүчин зүйлийн нэг юм. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс хийсэн судалгаагаар хуванцар саванд хадгалсан усан дахь хар тугалгын шилжилтийн хэмжээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ болон Монгол Улсад мөрдөж байгаа стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 60-800, формальдегид 1800-6900 дахин их байгааг тус тус тогтоосон.

3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Нарантуул” худалдааны төвд борлуулагдаж байгаа зориулалтын бус хуванцар саванд хонуулсан усны дээжид хийсэн химийн бодис, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох шинжилгээгээр аммиакийн агууламж төвлөрсөн сүлжээний усан дахь агууламжаас 48, төмөр 2, нитрит 11 дахин тус тус их гарсан бөгөөд хадгалах хугацаа нэмэгдэх тусам химийн бодисын шилжилт нэмэгдэж байгааг тогтоосон.

4. Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбооны судалгаанаас үзвэл, Монгол Улс жилд 500 орчим тэрбум төгрөгийн сав, баглаа боодол хэрэглэж байна. Гэвч нийт хэрэгцээний 30 хүрэхгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа дүнтэй. Энэ салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах, уламжлалт сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжих бодит шаардлага тулгараад байна.

...ooOoo...